ARD КРЕДИТ ББСБ

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 30-ны өдөр № 2025/26 Улаанбаатар хот

Сонирхолын зөрчилтэй
хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2, 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1, 92.4 дэх заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн О.Одбаярын нэгдмэл сонирхолтой этгээд болох түүний хүү О.Одсайханд 19,000,000 (арван есөн сая) төгрөгийн хэрэглээний зээлийг дараах нөхцөлөөр олгохыг зөвшөөрсүгэй.

| | |
|---|---|
| **Зээлийн хүү** | 42% /жилийн / |
| **Зээлийн хугацаа** | 18 сар |
| **Зээл олголтын шимтгэл** | 1% |
| **Эргэн төлөх нөхцөл** | Сар бүр үндсэн зээл, хүүгийн хамт |
| **Зээлийн зориулалт** | Хувийн хэрэгцээнд |

2. Зээлийн гэрээ байгуулсантай холбогдуулан зээлийн гэрээний үүргийг хангах баталгаа болгож, О.Одбаяртай батлан даалтын гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтийг хангуулан зээлийн гэрээ болон батлан даалтын гэрээ байгуулах, компанийг төлөөлж холбогдох бичиг баримтад гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар), зээл олголтыг хийх эрхийг Санхүү эрхэлсэн захирал (Ч.Гэндэнпил) нарт тус тус олгосугай.

4. Энэхүү санал хураалтад сонирхлын зөрчилгүй этгээдүүд оролцож шийдвэр гаргасан болохыг дурдсугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын Хороо (В.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ГАНЗОРИГ

УЛААНБААТАР ХОТ
АРД КРЕДИТ ББСБ ХК